



**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2017 ОНЫ
3-Р УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА**

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

АГУУЛГА

1. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	3
1.1. Ерөнхий төлөв байдал	3
1.2. Статистик үзүүлэлтүүд	3
2. АКТИВЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН ӨӨРЧЛӨЛТ	5
2.1. Активын бүтэц, түүний өөрчлөлт	5
2.2. Зээлийн багцын чанар	5
2.3. Зээлийн зориулалт	6
2.4. Активын бусад үзүүлэлт	7
3.1. Пассивын бүтэц, түүний өөрчлөлт	7
4. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА	9
4.1. Орлого	9
4.2. Зардал	9
4.3. Ашигт ажиллагаа	9
5.САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД	10
5.1. Орон нутаг дахь банк бус санхүүгийн байгууллага	10
5.2. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ	11
ДҮГНЭЛТ	14

1. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1. Ерөнхий төлөв байдал

2017 оны 3-р улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх ББСБ-уудын тоо 535-д хүрч 2016 оны 3-р улирлаас 5.1 хувиар, 2011 оны мөн үеэс 2.8 дахин нэмэгдсэн байна. Хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудын хувьд 2014 оны 3-р улиралд 48.1 хувиар өсөж байсан бол түүнээс хойш буурсаар 2017 оны 3-р улиралд 18.6 хувь болсон.

2011 оноос хойш ББСБ-уудын тооны өсөлтийг харвал 2014 онд хамгийн өндөр буюу 43.3 хувийн өсөлттэй байсан бол түүнээс хойш өсөлтийн хурд саарч нэг орон тоо тоонд хүрсэн байна. Ялангуяа тайлант улиралд нийт ББСБ-уудын өсөлт 2017 оны 3-р улиралд 5.1 хувьд хүрсэн нь эдийн засгийн бизнест нөлөөлж буй хүндрэл бэрхшээл болон ББСБ-уудын дүрмийн санг нэмэгдүүлэх шийдвэр нөлөөлсөн байж болох юм.

2017 онд тайлант улирлын байдлаар өссөн дүнгээр Хорооны хуралдаанаар 29 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, 12 компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгох, 20 компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 7 компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан эрхлэх үйл ажиллагааны төрлөөр ББСБ-уудын ангилал

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өсөлт	
		2016-III	2017-III	тоо	хувь
Нийт ББСБ		509	535	26	5.1%
1	Зээлийн үйл ажиллагаа	454	482	28	6.2%
Үүнээс: Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг		337	358	21	6.2%
2	Факторонгийн үйлчилгээ	22	22	0	0.0%
3	Төлбөрийн баталгаа гаргах	16	16	0	0.0%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	2	2	0	0.0%
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	12	15	3	25.0%
6	Гадаад валютын арилжаа	143	147	4	2.8%
Үүнээс: Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг		51	50	-1	-2.0%
7	Итгэлцлийн үйлчилгээ	28	27	-1	-3.6%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	6	4	200.0%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	33	31	-2	-6.1%

2017 оны 3-р улирлын байдлаар нийт 72 ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөгдөж нийт ХНХ-хэмжээ 26,238.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нэгдсэн бүртгэлийн байдлаар 1 ББСБ-ын оноосон нэр өөрчлөлт, 10 ББСБ-ын хаяг өөрчлөгдөж, 15 ББСБ-ын гүйцэтгэх захирал өөрчлөгдсөн.

Мөн 2017 оны 2-р улирлын байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай 33 ББСБ-ууд байснаас 3 ББСБ хүчингүй, 2 ББСБ 100% Монголын хөрөнгө оруулалттай болж, 1 ББСБ 100% гадаадын хөрөнгө оруулалттай болсноор тус 3-р улиралд гадаадын хөрөнгө оруулалттай нийт 29 ББСБ болж өөрчлөгдсөн болно.

1.2. Статистик үзүүлэлтүүд

2017 оны 3-р улиралд тайлан мэдээг ирүүлбэл зохих 535 ББСБ-аас 514 ББСБ /96.1%/ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан.

Хувьцаа эзэмшигчдийн тоо 102-оор буюу 10.9 хувиар нэмэгдэж 1,039, салбарт ажиллагсдын тоо 414-өөр буюу 22.1 хувиар нэмэгдэж 2,289-т хүрлээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 63.1 хувь нь эрэгтэй ба нийт салбарт ажиллагсдын 44.2 эрэгтэй байна. Тайлант хугацааны голлох статистик үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харуулбал:

Хүснэгт 2. Ерөнхий статистик үзүүлэлт 1 /сая.төг/

№	Үзүүлэлтүүд	2016-III	2017-III	Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	хувь
1	Нийт ББСБ тоо	509	535	26	5.1%
Үүнээс: хөдөө орон нутагт		59	70	11	18.6%
2	Харилцагчдын тоо	432,704	1,392,561	959,857	221.8%
Үүнээс: эмэгтэй		46,886	692,037	645,151	1376.0%
Хуулийн этгээд		3,419	2,516	(903)	-26.4%
3	Хувьцаа эзэмшигчдийн тоо	937	1,039	102	10.9%
Үүнээс эмэгтэй		314	383	69	22%
4	Ажиллагсдын тоо	1,875	2,289	414	22.1%
Үүнээс эмэгтэй		1,095	1,278	183	16.7%
5	Салбар нэгжийн тоо	117	139	22	18.8%
Үүнээс: Улаанбаатар хотод		87	103	15	17.2%
Үүнээс: Хөдөө орон нутагт		30	36	7	23.3%
6	Төлөөлөгчийн газар	4	4	-	0.0%

ББСБ-уудын харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 959,857-аар буюу 2 дахин өссөн ба ББСБ-ын цахим мөнгөний үйлчилгээний харилцагчдын тоо өсөлтөд голлон нөлөөлсөн байна. Нийт харилцагчдын 49.7 хувь нь эрэгтэй, 50.1 хувь эмэгтэй, үлдсэн 0.2 хувь нь хуулийн этгээд байна. Мөн нийт зээлдэгчид нь

102,957 бөгөөд түүний 91.9 хувь буюу 94,673 нь хэвийн, 2.9 хувь буюу 3,007 нь хугацаа хэтэрсэн, 5.1 хувь буюу 5,277 нь чанаргүй зээлдэгчид байна.

Салбар нэгжийн 74.1 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг ба түүний 6 салбар төлөөлөгч нь гадаад валют арилжаагаар үйл ажиллагаа явуулж байна.


ББСБ-уудын нийт актив өмнөх оны мөн үеэс 181,827.2 сая төгрөгөөр өсөж 905,980.8 сая төгрөгт, өөрийн хөрөнгө 185,759.6 сая төгрөгөөр өсөж 716,838.0 сая төгрөгт, үүний хувьцаат капитал 174,207.9 сая төгрөгөөр өсөж 575,821.1 сая төгрөгт хүрлээ.

Хүснэгт 3. Ерөнхий статистик үзүүлэлт 2 /сая.төг/

№	Үзүүлэлтүүд	2016-III	2017-III	Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	хувь
1	Нийт хөрөнгө	724,153.6	905,980.8	181,827.2	25.1%
2	Нийт зээл	447,715.8	592,409.7	144,693.9	32.3%
3	Нийт өөрийн хөрөнгө	531,078.4	716,838.0	185,759.6	35.0%
4	Хувьцаат капитал	401,613.2	575,821.1	174,207.9	43.4%
5	Нийт орлого	143,286.5	138,615.2	(4,671.4)	-3.3%
6	Нийт зарлага	99,019.2	94,945.8	(4,073.4)	-4.1%
7	Цэвэр ашиг/алдагдал	44,267.3	43,674.5	(592.8)	-1.3%

Тайлант улиралд 905,980.8 сая төгрөгийн хөрөнгөөр нийт санхүүгийн зах зээлийн 3.1 хувийг эзлэх бөгөөд 2016 оны жилийн эцсээс 0.1 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Нийт санхүүгийн зах зээлийн ашгийн 16 хувь, өөрийн хөрөнгийн 17.7 хувийг эзэлсэн байна.

Зураг 1. ББСБ-уудын тоон үзүүлэлтүүд



Монгол Улсын Эдийн засаг 2011 оноос сайжрах төлөвтэй байсан бөгөөд 4 жилийн хугацаанд бизнес эрхлэлт иргэдийн орлого дээшилж, зээлийн эргэн төлөлт сайжирсан ба улмаар ББСБ-уудын тоо хурдацтай өсөж харилцагчдын тоо болон ажлын байр нэмэгдэж хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байсан. Үүнээс хойш эдийн засгийн удаашрал бий болж иргэдийн орлого, бизнес эрхлэгчдийн ашиг буурснаар ББСБ-уудын эргэн төлөлт муудах, зээл хүсэгчийн зээл авах сонирхол багасах төлөвтэй байна.

Улсын хэмжээнд 535 ББСБ тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 13.1 хувь буюу 70 нь хөдөө орон нутагт, 86.9 хувь буюу 465 нь банк, санхүүгийн үйлчилгээний төвлөрөл, хүн амын нягтаршлаа дагаад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.


Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 70 ББСБ-уудын хамгийн их 22 ББСБ буюу 31.4 хувь нь төвийн бүсэд, 21 ББСБ буюу 30.0 хувь нь хангайн бүсэд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 4. Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын тархалт /бүсээр/

Бүсээр	ББСБ тоо	Эзлэх хувь
Төвийн бүс	22	31.4%
Хангайн бүс	21	30.0%
Зүүн бүс	12	17.1%
Баруун бүс	11	15.7%
Говийн бүс	4	5.7%
Нийт бүс	70	100.0%

Тайлант улиралд нийт ББСБ-уудын 45.8 хувь буюу 245 ББСБ нь санхүүгийн програмтай ба 16 нь гадаад валют арилжаа эрхэлж буй ББСБ-ууд хэрэглэж байна.

Зураг 2. Програм ашиглалт



Нийт ББСБ-уудын 45.8 хувь буюу 245 нь санхүүгийн программ ашиглаж байна. Санхүүгийн программ ашиглаж буй ББСБ-уудын 93.5 хувь буюу 229 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

2. АКТИВЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН ӨӨРЧЛӨЛТ

2.1. Активын бүтэц, түүний өөрчлөлт

2017 оны 3-р улирлын байдлаар ББСБ-уудын актив хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

Хүснэгт 5. Хөрөнгийн статистик /сая.төг/

№	ХӨРӨНГӨ	2016-III		2017-III		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Эргэлтийн хөрөнгө	695,227.0	96.0%	868,820.3	95.9%	173,593.2	25.0%
1	Мөнгөн хөрөнгө	210,184.1	29.0%	247,767.0	27.3%	37,582.9	17.9%
2	БХХО-лт /цэврээр/	1,300.5	0.2%	4,347.7	0.5%	3,047.2	234.3%
3	Нийт зээл	447,715.8	61.8%	592,409.7	65.4%	144,693.9	32.3%
	(Зээлийн эрсдэлийн сан)	(37,903.8)	5.2%	(53,371.2)	5.9%	(15,467.4)	40.8%
4	Нийт факторингийн тооцооны авлага	37.8	0.0%	30.0	0.0%	-7.8	-20.6%
	(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	(30.0)	0.0%	(30.0)	0.0%	(0.0)	0.0%
5	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	3,240.3	0.4%	5,923.4	0.7%	2,683.1	82.8%
6	Бусад хөрөнгө	70,682.3	9.8%	71,743.6	7.9%	1,061.3	1.5%
Б	Эргэлтийн бус хөрөнгө	28,926.6	4.0%	37,160.6	4.1%	8,234.0	28.5%
7	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	36,185.9	5.0%	45,610.7	5.0%	9,424.8	26.0%
	(Хуримтлагдсан эзлэгдэл)	(7,259.3)	1.0%	(8,450.1)	0.9%	(1,190.8)	16.4%
НИЙТ ХӨРӨНГӨ		724,153.6	100.0%	905,980.8	100.0%	181,827.2	25.1%

Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 25.1 хувиар өсөж 905,980.8 сая төгрөгт хүрлээ. Нийт активын бүтцийг авч үзвэл 95.9 хувийг эргэлтийн хөрөнгө, 4.1 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаагийн 65.4 хувь нь нийт зээлийн өрийн үлдэгдэл, 27.3 хувь нь мөнгөн хөрөнгө, 7.9 хувь нь бусад хөрөнгө байна.

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын активын бүтцийн гол өөрчлөлтүүдийг харвал нийт активд эзлэх зээлийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 144,693.9 сая төгрөгөөр, богино хугацаат хөрөнгө оруулалт 3,047.2 сая төгрөгөөр, өмчлөх болон өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө 2,683.1 сая төгрөгөөр, бусад хөрөнгө 1,061.3 сая төгрөгөөр тус тус өслөө.

Хүснэгт 6. Нийт актив бүлгээр /сая.төг/

Интервал	ББСБ тоо	Дүн /сая.төг/	Эзлэх хувь
10.0 тэрбум төгрөгөөс дээш	13	245,718.1	27.1%
5.0-9.9 тэрбум төгрөг хүртэл	14	101,564.89	11.2%
1.0-4.9 тэрбум төгрөг хүртэл	199	374,052.39	41.3%
0.5-0.9 тэрбум төгрөг хүртэл	194	167,115.93	18.4%
0.4 тэрбум төгрөгөөс доош	115	17,529.46	1.9%
НИЙТ	535	905,980.8	100.0%

Нэгтгэлийн дүнгээр нийт активын төвлөрлийг харахад 10.0 тэрбум төгрөгөөс дээш активтай 13 ББСБ-ын 245,718.1 сая төгрөгийн актив нь нийт активын 27.1 хувийг, 5.0 тэрбумаас 9 тэрбум хүртэлх төгрөгийн активтай 14 ББСБ-ын 101,564.89 сая төгрөгийн актив нь нийт активын 11.2 хувийг, 1.0 тэрбумаас 4.9 тэрбум хүртэлх төгрөгийн активтай 199 ББСБ-ын 374,052.39

сая төгрөгийн актив нь нийт активын 41.3 хувийг, 500.0 сая төгрөгөөс 999.0 сая хүртэлх төгрөгийн активтай 194 ББСБ-ын 167,115.93 сая төгрөгийн актив нь нийт активын 18.4 хувийг, 400.0 сая төгрөгөөс доош активтай 115 ББСБ-ын 17,529.46 сая төгрөгийн актив нь нийт активын 1.9 хувийг тус тус эзэлж байна.

2.2. Зээлийн багцын чанар

ББСБ-уудын зээлдэгчдийн тоо тайлант улиралд 102,957-д хүрч үүнээс 92.0 хувь буюу 94,673 нь

хэвийн, 3,007 буюу 2.9 хувийг хугацаа хэтэрсэн, 5,277 буюу 5.1 хувийг чанаргүй зээлдэгчид эзэлж байна.

Хүснэгт 5. Ерөнхий статистик үзүүлэлт 2

Үзүүлэлтүүд	Дүн	Эзлэх хувь
Нийт харилцагчдын тоо /оны эхнээс өссөн дүнгээр/	1,392,561	7.9%
Үүнээс: Эмэгтэй	692,037	7.8%
Хуулийн этгээд	2,516	0.2%
Нийт зээлдэгчдийн тоо	102,957	100.0%
Хэвийн	94,673	92.0%
Хугацаа хэтэрсэн	3,007	2.9%
Чанаргүй:	5,277	5.1%
-Хэвийн бус	1,203	1.2%
-Эргэлзээтэй	1,054	1.0%
-Муу	3,020	2.9%
Зээлдэгчдийн насжилт	101,860	100.0%
18-35 насны	48,760	47.9%
36-45 насны	32,292	31.7%
46-55 насны	15,316	15.0%
55-аас дээш	5,492	5.4%
Зээлдэгчдийн боловсрол	101,860	100.0%
Дээд	61,148	60.0%
-Тусгай дунд	18,034	17.7%
-Бүрэн дунд	15,343	15.1%
-Дунд	3,190	3.1%
-Бага	4,145	4.1%

Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 144,693.9 сая төгрөгөөр, өмнөх улирлаас 37,470.9 сая төгрөгөөр өсөж, 592,409.7 сая төгрөгт хүрлээ.

Нийт зээлийн 558,876.8 сая төгрөг буюу 94.3 хувь нь төгрөгийн, 33,532.9 сая төгрөг буюу 5.7 хувь нь валютаар олгосон зээл байна.

Төгрөгөөр олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 150,402.2 төгрөгөөр буюу 36.8 хувиар өссөн бол валютаар олгосон зээлийн хэмжээ 5,708.3 сая төгрөгөөр буюу 14.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Нийт зээлийн үлдэгдлийн 79.9 хувийг хугацаандаа байгаа зээл, 5.7 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 14.3 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна.

Хүснэгт 6. Зээлийн чанар /сая.төг/

№	Ангилал	2016-III	2017-III	Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	хувь
1	Хэвийн	369,664.3	473,416.7	103,752.4	28.1%
2	Хугацаа хэтэрсэн	21,872.0	34,280.8	12,408.8	56.7%
3	Чанаргүй зээл:	56,179.5	84,712.2	28,532.7	50.8%
	Хэвийн бус	16,664.7	14,593.8	(2,070.9)	-12.4%
	Эргэлзээтэй	15,660.9	18,559.6	2,898.6	18.5%
	Муу	23,853.8	51,558.9	27,705.0	116.1%
4	(Зээлийн эрсдэлийн сан)	37,903.8	53,371.2	15,467.4	40.8%
	Нийт зээл	447,715.8	592,409.7	144,693.9	32.3%
1	Үүнээс: Төгрөгийн	408,474.6	558,876.8	150,402.2	36.8%
2	Гадаад валютын	39,241.2	33,532.9	(5,708.3)	-14.5%

Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 28,532.7 сая төгрөг буюу 50.8 хувиар өссөн бөгөөд үүнд муу зээл хамгийн их буюу 1.2 дахин өссөн байна.

Зураг 3. Төгрөгийн зээл, валютын зээлийн харьцаа /хувиар/



2.3. Зээлийн зориулалт

Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл шинээр олгосон зээлийн 40.2 хувь буюу 190,381.0 сая төгрөг нь хэрэглээ, 26.3 хувь буюу 124,625.4 сая төгрөг нь бөөний жижиглэн худалдааны салбар, 11.9 хувь буюу 56,220.4 сая төгрөг нь барилгын салбар, 3.7 хувь буюу 17,559.7 сая төгрөг нь уул уурхай зэрэг салбар, 3.4 хувь буюу 15,967.2 сая төгрөг нь боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудад тус тус олгогдсон байна.

Нийт олгосон зээлийн эргэн төлөлтийг эдийн засгийн гол салбараар авч үзвэл хэрэглээний зээлээс 150,236.1 сая төгрөг, худалдааны салбараас 93,394.1 сая төгрөг, барилгын салбараас 41,482.3 сая төгрөг, уул уурхайн салбараас 11,089.5 сая төгрөг, боловсруулах үйлдвэрлэлийн салбараас 10,785.6 сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Зураг 4. Олгосон болон төлөгдсөн зээлийн эзлэх хувь /зориулалтаар/




Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 221,489.1 сая төгрөг буюу 37.4 хувь нь хэрэглээнд, 147,016.6 сая төгрөг буюу 24.8 хувь нь худалдааны салбарт, 94,536.7 сая төгрөг буюу 16 хувь нь барилгын салбарт, үлдсэн 21.8 хувь нь бусад салбарт байна. Нийт зээлийн үлдэгдлийн 78.2 хувь нь гуравхан салбарт төвлөрч байгаа нь эдгээр салбаруудад хүндрэл үүсэхэд салбарын зээлийн чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Зураг 5. Нийт зээлийн үлдэгдэл эзлэх хувь /зориулалтаар/




Зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар, өмнөх улирлаас 0.1 хувиар буурч 2017 оны 3-р улиралд 3.4 хувьд хүрсэн байна. Хорооноос хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөх шийдвэр гарснаас хойш зээлийн жигнэсэн дундаж хүү буурах хандлагатай байгаа бөгөөд зэх зээлийн өрсөлдөөн эдийн засгийн зарчмаар зарим ББСБ-ууд аль хэдийн зээлийн хүүгээ бууруулж буйгаа илэрхийлж эхлээд байна.

Зураг 6. Зээлийн жигнэсэн дундаж хүү /улирлаар/



Зураг 7. Авлага төгрөг, валют /хувиар/



Нийт 18,128.0 сая төгрөгийн авлагаас 87.7 хувь буюу 15,905.1 сая төгрөг нь төгрөгийн авлага ба үлдсэн 12.3 хувь нь валютын авлага үүссэн байна.

2.4. Активын бусад үзүүлэлт

Тайлант улиралд 25 ББСБ богино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгсэлд 4,347.7 сая төгрөг байршуулсны 2,409.5 сая төгрөгийг 10 ББСБ-ын Засгийн газрын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт, 1,890.0 сая төгрөгийг 10 ББСБ-ын хувьцаагаарх хөрөнгө оруулалт бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс болон оны эхнээс 3,047.2 сая төгрөгөөр буюу 2.3 дахин өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 7. Богино хугацаат хөрөнгө оруулалт /сая.төг/

Богино хугацаат хөрөнгө оруулалт задаргаа	2016-III	2017-III	Өөрчлөлтийн дүн
Засгийн газрын	-	2,909.5	2,909.5
Хувьцаа	1,294.5	1,237.8	(56.7)
Нийт богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	1,300.5	4,347.7	3,047.2

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 535 ББСБ нь 37,160.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгөнд 8,450.1 сая төгрөгийн элэгдэл тооцсон байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгө /сая.төг/

Үзүүлэлт	2016-III	2017-III	Өөрчлөлт	
			дүн	хувь
Үндсэн хөрөнгө (цэврээр)	28,926.6	37,160.6	8,234.0	28.5%
Үндсэн ба биет бус хөрөнгө	36,185.9	45,610.7	9,424.8	26.0%
Биет бус хөрөнгө	4,443.5	4,250.4	(193.1)	-4.3%
Хуримтлагдсан элэгдэл	7,259.3	8,450.1	1,190.8	16.4%
Барилга байгууламж	685.3	1,139.1	453.8	66.2%
Техник хэрэгсэл	4,576.5	5,322.8	746.4	16.3%
Тавилга эд хогшил	1,997.5	1,988.1	(9.4)	-0.5%

3. ПАССИВЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, ӨӨРЧЛӨЛТ

3.1. Пассивын бүтэц, түүний өөрчлөлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө 25 хувиар буюу 181,827.2 сая төгрөгөөр өсөж түүнийг бүрдүүлэгч өр төлбөрийн хэмжээ 2017 оны 3-р улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 2 хувиар буурч 189,142.9 сая төгрөгт хүрлээ.

Хүснэгт 9. Өр төлбөр ба эздийн өмч /сая.төг/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	2016-III		2017-III		Өөрчлөлт	
		ДҮН	ХУВЬ	ДҮН	ХУВЬ	ДҮН	ХУВЬ
A	Нийт өр төлбөр	193,075.3	27%	189,142.9	20.9%	(3,932.4)	-2%
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	28,389.6	4%	35,616.7	3.9%	7,227.1	25%
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	116,159.0	16%	104,913.6	11.6%	(11,245.4)	-10%
3	Бусад эх үүсвэр	3,526.2	0%	3,681.6	0.4%	155.4	4%
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	4,298.9	1%	4,458.4	0.5%	159.6	4%
5	Төслийн зээлийн санхүүжилт	19,326.3	3%	15,926.3	1.8%	(3,399.9)	-18%
6	Бусад өр төлбөр	21,375.3	3%	24,546.2	2.7%	3,170.9	15%
Б	Өөрийн хөрөнгө	531,078.4	73%	716,838.0	79.1%	185,759.6	35%
9	Хувьцаат капитал	401,613.2	55%	575,821.1	63.6%	174,207.9	43%
10	Бусад өмч	8,360.8	1%	6,577.3	0.7%	(1,783.4)	-21%
11	Сангууд	481.7	0%	419.0	0.0%	(62.8)	-13%
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	119,623.9	17%	133,314.0	14.7%	13,690.1	11%
13	Хоёрдогч өглөг	998.8	0%	706.6	0.1%	(292.2)	-29%
	НИЙТ ПАССИВ ХӨРӨНГӨ	724,153.6	100%	905,980.8	100.0%	181,827.2	25%

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өөрийн хөрөнгө 185,759.6 сая төгрөгөөр буюу 35 хувиар өсөж нийт хөрөнгөнд эзлэх хувь хэмжээ 6.1 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнд хувьцаат капитал 43 хувиар буюу 174,207.9 сая төгрөгөөр, хуримтлагдсан ашиг 11 хувиар буюу 13,690.1 сая төгрөгөөр өссөн голчлон нөлөөлсөн байна. Бусад өмч, сангууд, хоёрдогч өглөгийн үзүүлэлтүүд дунджаар 21 хувиар буурсан.


Харин өр төлбөр өмнөх оны мөн үеэс 2 хувиар буурч нийт хөрөнгөнд эзлэх хувь хэмжээ нь 5.1 хувиар буурсан ба түүнийг бүрдүүлэгч төслийн зээлийн санхүүжилт хамгийн их 18 хувийн бууралттай байна.

Хүснэгт 102. Хувь нийлүүлсэн хөрөнгө /интервалиар/

Интервал	ББСБ тоо	Дүн /сая.төг/
5.0–13.9 тэрбум хүртэлх	11	82,521.2
2.5–4.9 тэрбум хүртэлх	40	118,804.4
1.0–2.4 тэрбум хүртэлх	127	166,039.6
0.8–0.9 тэрбум хүртэлх	235	190,168.5
0.2–0.7 тэрбум хүртэлх	35	11,261.6
0.2–с доош хүртэлх	87	7,232.6
Нийт	535	576,027.9


2017 оны тайлант улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 27 ББСБ-ын 21 ББСБ 35,616.7 сая төгрөгийг итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн. Эдгээр 21 ББСБ-уудын нийт хөрөнгө нь салбарын нийт хөрөнгийн 24.7 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө нь салбарын мөн үзүүлэлтийн 13.7 хувийг эзэлж байна.

Зураг 8. Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /сая.төг/



Банк санхүүгийн байгууллагад өгөх өглөг хугацааны хувьд 2014 оноос хойш тайлант улиралд тогтмол буурч байна. 2017 оны 3-р улирлын байдлаар 104,913.6 сая төгрөг буюу 11.6 хувийг эзэлж байна.

Зураг 9. Сангууд болон хуримтлагдсан ашиг, алдагдал /сая.төг/



Хуримтлагдсан ашиг 2011 оноос хойш өссөөр тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар буюу 13,690.1 сая төгрөгөөр өсөж 133,314.0 сая төгрөгт хүрсэн байна. Сангуудын дүн 2013 онд огцом буурч 2016 оны тайлант улирал хүртэл өссөн үзүүлэлттэй байна.

2017 оны тайлант улиралд нэр бүхий 6 ББСБ-ын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 856.6 сая төгрөг, нэр бүхий 1 ББСБ-ын төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 2,825.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөн нэр бүхий 5 ББСБ нийт 706.6 сая төгрөгийг хоёрдогч өглөгөөр татан төвлөрүүлсэн байна.

4. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

4.1. Орлого

2017 оны 3-р улирлын байдлаар ББСБ-уудын нийт орлого өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар буурсан ба тус бууралтад хүүгийн бус орлогын бууралт голчлон нөлөөлсөн байна.

Нийт орлогын 83 хувийг хүүгийн орлого, 13.4 хувийг хүүгийн бус орлого, 3.5 хувийг үндсэн бус үйл ажиллагааны орлого бүрдүүлж байна.

Хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны орлого 58.1 хувиар өссөн бол хүүгийн бус орлого 51.3 хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа.

2017 оны тайлант улирлын байдлаар нийт хүүгийн орлогын 110,237.7 сая төгрөг буюу 95.9 хувийг хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого, 4,094.7 сая төгрөг буюу 3.6 хувийг хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого, 3,273.4 сая төгрөг буюу 2.9 хувийг банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого бүрдүүлж байна.

Хүүгийн бус орлогын 2,796.3 сая төгрөг буюу 14.3 хувийг арилжааны орлого, 7,783.2 сая төгрөг буюу 39.7 хувийг санхүүгийн үйлчилгээний орлого, 4,092.4 сая төгрөг буюу 20.9 хувийг үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого тус тус эзэлж байна.

4.2. Зардал

2017 оны 3-р улиралд нийт зардал өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар буурлаа.

Нийт зардлын 61.9 хувийг хүүгийн бус зардал, 19.4 хувийг болзошгүй эрсдэлийн зардал, 11.3 хувийг хүүгийн зардал, 6.3 хувийг орлогын татварын зардал бүрдүүлж байна.

Нийт зардал өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар буурсан нь хүүгийн бус зардал 9.1 хувиар, хүүгийн зардал 8.8 хувиар буурсан нь голчлон нөлөө үзүүлсэн байна.

Хүүгийн зардлын 48.5 хувийг бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал, 33.7 хувийг банкны зээлийн хүүгийн зардал, 11.9 хувийг төслийн зээлийн хүүгийн зардал, 6.1 хувийг өрийн бичгийн хүүгийн зардал эзэлж байна.

Хүүгийн бус зардлын 43.1 хувийг бусад зардал, 39.1 хувийг боловсон хүчний зардал, 17.9 хувийг арилжааны болон ханшийн тэгшитгэлийн зардал бүрдүүлж байна.

4.3. Ашигт ажиллагаа

ББСБ-уудын ашигт ажиллагаа өнгөрсөн оны мөн үеэс 592.8 сая төгрөгөөр буюу 1.3 хувиар буурч 43,674.5 сая төгрөгт хүрлээ.

Хүснэгт 113. Нийт орлого, зарлага /сая.төг/

№	Үзүүлэлт	2016-III	2017-III	Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	хувь
1	Нийт орлого	143,286.5	138,615.2	(4,671.4)	-3.3%
2	Нийт зарлага	99,019.2	94,945.8	(4,073.4)	-4.1%
ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ		44,267.3	43,674.5	(592.8)	-1.3%

Салбарын хэмжээнд нийт 535 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 80 хувь буюу 428 ББСБ 52,325.7 сая төгрөгийн ашигтай, 3.9 хувь буюу 21 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 16.1 хувь буюу 86 ББСБ 8,651.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Сүүлийн 5 жилийн дүн мэдээнээс харахад ББСБ-уудын ашигт ажиллагааны үзүүлэлт 2013 онд өмнөх оны мөн үеэс 56.4 хувиар өсөөд байсан бол 2014 оноос эхлэн өсөлтийн хурдац нь саарсаар 2017 оны эхний хагаст 12.4 хувиар өсөж тайлант 3-р улиралд 1.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 14. Ашгийн өсөлт хугацааны цуваагаар /сая.төг/

Огноо	Орлого	Зарлага	Цэвэр ашиг/алдагдал	Ашгийн өсөлт
2013-III	72,051.9	51,006.8	21,045.1	56.4%
2014-III	99,398.8	72,446.9	26,951.8	28.1%
2015-III	115,492.8	82,316.9	33,175.8	23.1%
2016-III	143,286.5	99,019.2	44,267.3	33.4%
2017-III	138,615.2	94,945.8	43,674.5	-1.3%

5. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

5.1. Орон нутаг дахь банк бус санхүүгийн байгууллага


Хөдөө орон нутаг дахь ББСБ-уудын нийт актив 2017 оны 3-р улирлын эцэст 22,804.3 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3,210.5 сая төгрөгөөр буюу 16.4 хувиар өссөнөөр салбарын нийт активын 2.5 хувийг бүрдүүлж байна. Нийт чанаргүй зээл өмнөх оны мөн үеэс 5.8 дахин буюу 2,828.5 сая төгрөгөөр өсөж нийт салбарын нийт зээлийн 3.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 15. Орон нутгийн ББСБ-уудын үндсэн үзүүлэлт /сая.төг/

ОРОН НУТАГ ББСБ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2016-III	2017-III	ӨСӨЛТ БУУРАЛТ ХЭМЖЭЭ
Орон нутаг ББСБ тоо	59	70	11
Орон нутаг салбарын ББСБ тоонд эзлэх хувь	11.6	13.1	1.5
Орон нутаг нийт актив	19,593.8	22,804.3	3,210.5
Орон нутаг ББСБ-ын нийт активд эзлэх хувь	2.7	2.5	(0.2)
Орон нутаг чанаргүй зээл	483.8	3,312.3	2,828.5
Орон нутаг ББСБ-ын нийт чанаргүй зээлд эзлэх хувь	0.9	3.9	3.0
Орон нутаг нийт өөрийн хөрөнгө	17,679.2	20,845.8	3,166.6
Орон нутаг ББСБ-ын нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь	3.3	2.9	(0.4)
Орон нутаг нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	13,854.5	18,324.7	4,470.3
Орон нутаг ББСБ-ын нийт хувь нийлүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь	3.4	3.2	(0.2)

Хүн амын суурьшил, орлого болон үйлдвэрлэл эрхлэлтээс хамаарч аймгууд дахь банк бус санхүүгийн салбарын активын хэмжээ харилцан адилгүй байна. Орон нутаг дахь ББСБ-уудын активын хэмжээг бүсээр ангилж авч үзвэл Төвийн бүсийн аймгууд дахь активын хэмжээ хамгийн их байгаа бол Баруун бүсийн аймгуудад хамгийн бага байна.

Зураг 10. Аймгуудын төвлөрөл активаар /Бүсээр/



Нийт орон нутаг дахь банк бус санхүүгийн байгууллагуудын активын 51.8 хувийг Төвийн бүс, 26.5 хувийг хангайн бүс, 7.5 хувийг Зүүн бүс, 7.6 хувийг говийн бүсийн аймгууд үлдсэн 6.5 хувийг баруун бүс тус тус бүрдүүлж байна.

Орон нутгийн чанаргүй зээл нь салбарын нийт зээлд эзлэх хувиар төвийн бүс хамгийн их буюу 0.5 хувьтай бөгөөд тайлант улиралд нийт чанаргүй зээл 2,937.6 сая төгрөгтэй байна.

5.2. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ

Тайлант улиралд гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 29 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын 5 хувь, тэдгээрийн актив нь салбарын 14.8 хувь, зээлийн өрийн үлдэгдэл нь салбарын 16.6 хувь, өөрийн хөрөнгө нь салбарын 8.9 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө нь салбарын 9.6 хувьтай тус тус тэнцэж байна.

Хүснэгт 1612. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын санхүүгийн үзүүлэлтүүд /сая.төг/

ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАЙ ББСБ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2016-III	2017-III	ӨСӨЛТ БУУРАЛТ
ГХО ББСБ тоо	30	29.0	(1)
ГХО ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	5.9	5.0	(0.9)
ГХО нийт актив	116,387.5	134,326.0	17,938.5
ГХО ББСБ-ын нийт активд эзлэх хувь	16.1	14.8	(1.3)
ГХО нийт зээлийн өрийн үлдэгдэл	82,529.2	98,374.8	15,845.6
Үүнээс: ГХО чанаргүй зээл	11,886.4	16,320.9	4,434.5
Нийт ББСБ-ын зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	18.4	16.6	(1.8)
ГХО нийт өөрийн хөрөнгө	58,440.5	63,915.4	5,474.9
ГХО ББСБ-ын нийт өмчид эзлэх хувь	11.0	8.9	(2.1)
ГХО Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	50,992.8	55,503.5	4,510.7
ГХО ББСБ-ын нийт хувь хөрөнгөнд эзлэх хувь	12.7	9.6	(3.1)

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Япон улсын хөрөнгө оруулалттай 10, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 7, Хонг Конгийн хөрөнгө оруулалттай 3, БНХАУ хөрөнгө оруулалттай 2, АНУ-ын хөрөнгө оруулалттай 2, Орос, Сичель, Франц, Англи, Люксембург, Малайз, Швейцарийн хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай 29 ББСБ-уудаас 18 нь 100 хувийн хөрөнгө оруулалттай ба хамтарсан АНУ болон Японы хөрөнгө оруулалттай 1 ББСБ байна. Япон улсын хөрөнгө оруулалттай 10 ББСБ байгаагаас 6 ББСБ нь 55 хувиас дээш хөрөнгө оруулалттай байна.

6. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Тусгай зөвшөөрөл эзэмшигч ББСБ-уудын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээг Хорооны 2016 оны 147 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын дагуу тооцож үзэхэд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 17. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	454	84.9%
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	54	10.1%
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	16	3.2%
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	7	1.3%
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	0.4%
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	0.4%
НИЙТ		535	100%

2017 оны 3-р улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 535 ББСБ-ын 84.9 хувь нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан бол 10.1 хувь нь 1 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 3.2 хувь нь 2 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 1.3 хувь нь 3 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 0.4 хувь нь 4 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 0.4 хувь нь 5 ба түүнээс дээш харьцаа үзүүлэлтийг хангаагүй ажилласан байна.

ЖУРМЫН 3.2-Т ЗААСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 18. Журмын 3.2 зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	47	88.7%
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	3.8%
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	4	7.5%
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
НИЙТ		53	100%

Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих зохистой харьцааны 6 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

1) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 50 ББСБ хангасан буюу биелэлт 94.3 хувь;

2) өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас доошгүй байх шаардлагыг 49 ББСБ хангасан буюу биелэлт 92.5 хувь;

3) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага 52 ББСБ хангасан буюу биелэлт 98.1 хувь;

4) төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг бүрэн;

Эдгээр 53 ББСБ-уудын хувьд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа үзүүлэлт харьцангуй хамгийн ихээр алдагдсан байна.

ЖУРМЫН 3.3-Т ЗААСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 19. Журмын 3.3 ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	366	84.5%
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	46	10.6%
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	12	2.8%
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	6	1.4%
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	0.5%
5	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	1	0.2%
НИЙТ		433	100.0%

Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих зохистой харьцааны 14 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

1) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 423 ББСБ хангасан буюу биелэлт 97.7 хувь;

2) өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 422 ББСБ хангасан буюу биелэлт 97.5 хувь;

3) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 431 ББСБ хангасан буюу биелэлт 99.5 хувь;

4) төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 423 ББСБ хангасан буюу биелэлт 97.7 хувь;

5) активын эрсдэлийн сангийн хүрэлцээний зөрүү 0 байх шаардлагыг 432 ББСБ хангасан буюу биелэлт 99.8 хувь;

6) нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлагыг 422 ББСБ хангасан буюу биелэлт 97.5 хувь;

7) нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн хэмжээ 10 хувиас ихгүй байх шаардлагыг 427 ББСБ хангасан буюу биелэлт 98.6 хувь;

8) нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлагыг 430 ББСБ хангасан буюу биелэлт 99.3 хувь;

Журмын 3.3–т заасан үйл ажиллагаа эрхлэх 433 хуулийн этгээдийн хувьд цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа, гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа, нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн харьцаа үзүүлэлтүүдийг 10–22 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

ЖУРМЫН 3.4–Т ЗААСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 20. Журмын 3.4 ББСБ–ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	ББСБ–ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ–ын тоо	41	83.7%
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ–ын тоо	6	12.2%
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ–ын тоо	0	0.0%
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ–ын тоо	1	2.0%
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ–ын тоо	0	0.0%
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ–ын тоо	1	2.0%
НИЙТ		49	100.0%

Журмын 3.4–т заасан хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих 18 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

1) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 98.0 хувь;

2) өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 98.0 хувь;

3) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 98.0 хувь;

4) төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 46 ББСБ хангасан буюу биелэлт 93.9 хувь;

5) активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийг 49 ББСБ бүрэн хангасан;

6) нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 98.0 хувь;

7) нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 10 хувиас ихгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 98.0 хувь ;

8) нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 98.0 хувь ;

9) итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн зохистой харьцаа 80 хувиас ихгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 98.0 хувь;

Журмын 3.4–т заасан үйл ажиллагаа эрхлэх 48 хуулийн этгээдийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа үзүүлэлтийг 1–2 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

ДҮГНЭЛТ

Тусгай зөвшөөрөлтэй 535 ББСБ-уудын 98.3 хувь нь буюу 526 ББСБ 2017 оны 3-р улирлын байдлаар тайлан, мэдээгээ зохих журмын дагуу ирүүлсэн нь өмнөх улирлын мөн үеэс 1.7 хувиар нэмэгдсэн байна.

Нийт ББСБ-ын 86.9 хувь буюу 465 нь Улаанбаатар хотод, 13.1 хувь буюу 70 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд бүсээр ангилбал 22 ББСБ нь төвийн бүсэд, 21 ББСБ нь хангайн бүсэд, 12 ББСБ нь зүүн бүсэд, 11 ББСБ нь зүүн бүсэд, 11 ББСБ нь баруун бүсэд, 4 ББСБ нь говийн бүсэд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хөдөө орон нутаг дахь ББСБ-уудын нийт чанаргүй зээл өмнөх оны мөн үеэс 50 дахин буюу 24,626.4 сая төгрөгөөр өсөж нийт хөдөө орон нутаг дахь ББСБ-ын нийт зээлийн 11.3 хувь, салбарын нийт зээлийн 4.2 хувийг эзэлж байна.

Банк бус санхүүгийн салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 25.1 хувиар өсөж, 905.9 тэрбум төгрөгт хүрлээ. Дүн нэгтгэлээрх нийт активын төвлөрлийг харахад 10.0 тэрбум төгрөгөөс дээш активтай 13 ББСБ-ын 245,718.1 сая төгрөгийн актив нь нийт активын 27.1 хувийг, 5.0 тэрбумаас 9 тэрбум хүртэлх төгрөгийн активтай 14 ББСБ-ын 101,564.89 сая төгрөгийн актив нь нийт активын 11.2 хувийг, 1.0 тэрбумаас 4.9 тэрбум хүртэлх төгрөгийн активтай 199 ББСБ-ын 374,052.39 сая төгрөгийн актив нь нийт активын 41.3 хувийг, 500.0 сая төгрөгөөс 999.0 сая хүртэлх төгрөгийн активтай 194 ББСБ-ын 167,115.93 сая төгрөгийн актив нь нийт активын 18.4 хувийг, 400.0 сая төгрөгөөс доош активтай 115 ББСБ-ын 17,529.46 сая төгрөгийн актив нь нийт активын 1.9 хувийг тус тус эзэлж байна.

Салбарын зээлийн хэмжээ өсөлттэй байгаа хэдий ч хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ эдийн засгийн тодорхой бус байдлаас үүдэн иргэд, хувийн хэвшлийн ашиг, орлого буурч байгаа нь зээлийн эргэн төлөлт удааширч, зээлийн чанар муудахад хүргэж байна.

2017 оны 3-р улирлын байдлаар нийт 473,822.7 сая төгрөгийн зээл олгож, үүнээс 357,394.9 сая төгрөгийн зээл эргэн төлөгдөж, нийт зээлийн өрийн үлдэгдэл 592,409.7 сая төгрөг байна. Шинээр олгосон зээлийн 40.2 хувь нь хэрэглээ, 26.3 хувь нь худалдааны салбар, 11.9 хувь нь барилгын салбар, 3.7 хувь уул уурхайн салбар, 3.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт тус тус олгогдсон байна.

Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын сарын жигнэсэн дундаж хүү 3.4 хувь байна. Энэ нь өмнөх оны мөн улирлаас 0.8 пунктээр, өмнөх улирлаас 0.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

ББСБ-уудын цэвэр ашигт өнгөрсөн оны мөн үеэс 592.8 сая төгрөгөөр буюу 1.3 хувиар буурч, 43,674.5 сая төгрөгт хүрлээ. Салбарын хэмжээнд нийт 535 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 80 хувь буюу 428 ББСБ 52,325.7 сая төгрөгийн ашигтай, 3.9 хувь буюу 21 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 16.1 хувь буюу 86 ББСБ 8,651.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР